Хавсралт ББЖ-02

National Life

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 02/23-41

Улаанбаатар хот

"Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам"-ыг батлах тухай

"Компанийн тухай хууль"-ийн 76 дугаар зүйлийн 76.1.13, "Нэйшнл лайф даатгал ХХК-ийн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.6.9-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын 1-р заалтаар журам батлагдсантай холбогдуулан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг журамд заасны дагуу 2023 оны 12 сарын 20-ны өдөрт багтаан бичгээр ТУЗ-ийн НБД-д ирүүлэхийг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтуудад даалгасугай.
3. "Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам"-ыг нийт ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Монголхүү/-д даалгасугай.
4. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА Ж.БАТ-ИРЭЭДҮЙ

УЛААНБААТАР ХОТ National Life НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ ХХК 1118269420 5156155 СБТ10099

*"Нэйшнл Лайф Даатгал" ХХК-ийн*
*ТУЗ-ийн 2023 оны 11 сарын 18-ны өдрийн*
*02/23-41 тоот тогтоолын хавсралт*

УЛААНБААТАР ХОТ National Life НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ ХХК 1118269420 5156955 СБТ10099

**СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ**

**1. НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам /цаашид "журам" гэх/-ын зорилго нь Компанийн тухай хуулийн 92.1, "Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн дүрмийн 5.6 дугаар зүйлийн 5.6.4.11 дэх заалтуудыг хэрэгжүүлэхэд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үйл ажиллагаанд оролцогч талуудын гүйцэтгэх үүргүүдийг тогтоож, уялдуулах замаар хувийн ашиг сонирхолтой холбоотойгоор компанид хохирол учруулахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. **Ашиг сонирхол** гэж тодорхой үйл ажиллагаанаас давуу тал олж авах, түүнээс үр шим хүртэх хүслийг;

1.2.2. **Хувийн ашиг сонирхол** гэж хувь хүн эсхүл бүлэг хүмүүс нийгмийн харилцаа, үйл ажиллагаанаас өөрт этгээдэд давуу тал олж авах, эерэг үр дүн, нөлөөлөлд хүрэх, эдгээрээс үр шим хүртэх хүслийг;

1.2.3. **Давуу тал гэж** зорилгыг хэрэгжүүлэх арга замын бусад сонголтуудтай харьцуулахад тухайн зорилгын хэрэгжилтэд илүү эерэг нөлөө бий болгох арга замын онцлог хэв шинж;

1.2.4. **Нэгдмэл сонирхолтой этгээд** гэж харилцан уялдаатай үүргүүдийг тогтвортой хэрэгжүүлэх замаар суурь хэрэгцээгээ хангах дундын нэгдмэл зорилгыг хэрэгжүүлдэг хувь хүн, хуулийн этгээдийг;

1.2.5. **Нэгдмэл зорилго** гэж ашиг сонирхол нь уялдсан оролцогч талууд тодорхой хугацаанд хүрэхээр төлөвлөж, харилцан хүлээн зөвшөөрсөн үр дүнг;

1.2.6. **Сонирхлын зөрчил** гэж шийдвэр гаргах үүрэг бүхий этгээдийн хувийн ашиг сонирхол нь компанийн нэгдмэл зорилгын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдлыг;

1.2.7. **Сонирхлын зөрчилтэй хэлцэл** гэж хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон компани хооронд хийж буй хэлцлийг;

1.2.8. **Хохирол** гэж зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд аливаа үйлдэл, эс үйлдлийн улмаас гарсан нэмэлт зардал болон зайлшгүй олох байсан орлогын алдагдлыг;

1.2.9. **Зардал** гэж зорилгодоо хүрэхэд шаардлагатай үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах мөнгөөр илэрхийлэгдэх нөөцийг;

1.2.10. **Урьдчилан сэргийлэх** гэж зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд учирч болзошгүй сөрөг нөлөөтэй саад, бэрхшээлийг даван туулах шийдлүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

1.2.11. **Журам** гэж Зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөх тодорхой хэв шинжийг бүрдүүлэхэд шаардлагатай, олон дахин давтагддаг үүргүүдийг тогтоож, тэдгээрийг хооронд нь уялдуулсан эрх зүйн баримт бичгийг;

1.2.12. **Бодлогын баримт бичиг** гэж стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь хэв шинжүүдийг тогтоож, тэдгээрийг хооронд нь уялдуулсан загварыг тусгасан баримт бичиг;

1.2.13. **Дүрэм** гэж зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зайлшгүй мөрдүүлэх суурь хэв шинжүүдийг болон шийдвэр гаргах хэм хэмжээг тогтоож, хоорондоо нь уялдуулсан эрх зүйн баримт бичиг;

1.2.14. **Шийдвэр** гэж компанийн удирдлагаас хууль, дүрэм, журамд заасан үүргээ хэрэгжүүлэхээр гаргаж буй, эрх зүйн актаар баталгаажсан, заавал биелэгдэх шинжтэй, албажуулсан баримт бичгийг;

1.2.15. **Шийдвэр гаргах** гэж зорилгыг хэрэгжүүлэх боломжит арга замын хувилбаруудаас оновчтойг сонгож албажуулахыг;

1.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл /цаашид СЗ-тэй хэлцэл гэх/-ийг хийх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:

1.3.1. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх үйл ажиллагаа компанид бий болох үр ашигт үндэслэдэг байх;

1.3.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснээр хүрэх үр дүнг нь тоон утгаар хэмждэг байх;

1.3.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үйл ажиллагааны гүйцэтгэл нь ил тод байх;

1.4. Энэхүү журмын зорилгын хэрэгжилтийн хэмжүүр үзүүлэлтүүдийг хавсралт **<u>СЗЖ-01 маягтад</u>** тусгав.

## 2. ХОЁР.СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ, ШИЙДВЭР ГАРГАХ ЭТГЭЭД

2.1. Дараах этгээдүүд нь компанитай байгуулах хэлцэлд хавсралт СХЖ-02 маягтад заасан хэлбэрээр оролцох тохиолдолд түүнийг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд гэж үзнэ.Үүнд:
- 2.1.1. Компанийн энгийн хувьцааны 20-оос дээш дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй хувьцаа эзэмшигч;
- 2.1.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан /цаашид ЭБАТ гэх/;
- 2.1.3. Энэ журмын 2.1.1, 2.1..2-д заасан этгээдийн нэгдмэл сонирхолтой этгээд;

2.2. Дараах этгээдүүд нь компанитай байгуулах хэлцэлд хавсралт СХЖ-02 маягтад заасан хэлбэрээр оролцох тохиолдолд уг хэлцлийг СЗ-тэй хэлцэл гэж үзнэ.Үүнд:
- 2.2.1. Компанийн энгийн хувьцааны 33.3-аас дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй хувьцаа эзэмшигч /цаашид хяналтын багц эзэмшигч гэх/;
- 2.2.2. ЭБАТ;
- 2.2.3. Энэ журмын 2.2.1, 2.2.2-д заасан этгээдийн нэгдмэл сонирхолтой этгээд;

2.3. ТУЗ нь СЗ-тэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55-д заасны дагуу тогтооно.

2.4. СЗ-тэй хэлцэл хийх этгээд нь компанитай дараах хэлцлийг хийхэд ТУЗ болон ХЭХ-аас зөвшөөрөл авах шаардлагагүй. Үүнд:
- 2.4.1. Компанийн тухай хуулийн 92.5-д заасан компанид зээл олгох гэрээ;
- 2.4.2. Компанийн тухай хуулийн 92.6-д заасан тухайн этгээдийн СЗ-тэй хэлцэл хийх этгээдээр тооцогдохоос өмнө компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан хэлцэл;
- 2.4.3. ТУЗ-өөс баталсан стандарт нөхцөл бүхий даатгалын гэрээ, түүнтэй холбогдох бусад гэрээ;
- 2.4.4. ТУЗ, ХЭХ-аас баталсан шийдлүүдэд заасны дагуу байгуулж буй гэрээ, хэлцэл;

2.5. СЗ-тэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг Компанийн тухай хуулийн 92.1-д заасан саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

2.6. Компанийн тухай хуулийн 92.3-д заасан үндэслэл бий болсон эсхүл саналын эрх бүхий ТУЗ-ийн олонхийн саналаар ХЭХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн бол уг хэлцлийг хийх эсэх асуудлыг сонирхлын зөрчилгүй Хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

2.7. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх шийдвэр гаргахад уг хэлцлийн хувьд сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн, хувьцаа эзэмшигч нь энэ талаар урьдчилан ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /НБД гэх/-д мэдэгдэх бөгөөд бөгөөд түүний эзгүйд асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.8. ЭБАТ болон энэ журмын 2.1.1-д заасан хувьцаа эзэмшигч нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалтыг СХЖ-03 маягтаар гаргаж дор дурдсаны дагуу ТУЗ-ийн НБД-д бичгээр хүргүүлнэ. Үүнд:
- 2.8.1. ЭБАТ нь албан тушаалд томилогдсоноос хойш хуанлийн 10 хоногийн дотор;
- 2.8.2. Хувьцаа эзэмшигч нь дангаараа болон өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг эзэмших болсноос хойш ажлын 10 хоногт багтаан;
- 2.8.3. Энэ журмын 2.8.1, 2.8.2-д заасан мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш хуанлийн 10 хоногийн дотор;

2.9. НБД нь СЗ-тэй хэлцэл хийх этгээдийн жагсаалтад СХЖ-04 маягтад энэ журмын 2.8-д заасны дагуу ирүүлсэнээс хойш ажлын 2 хоногт багтаан бүртгэнэ.

## 3. ГУРАВ.СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ, ТАЙЛАГНАХ

3.1. СЗ-тэй хэлцэл хийх этгээд нь компанитай хэлцэл хийхээс өмнө холбогдох баримт бичгийг хавсарган СХЖ-05 маягтын дагуу дор дурдсан этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Үүнд:
- 3.1.1. НБД нь ТУЗ-ийн даргад;;
- 3.1.2. Энэ журмын 3.1.1-д зааснаас бусад этгээд нь НБД-д;

3.2. Ажилтан нь хэлцлийн оролцогч тал энэ журмын 2.1-д заасан СЗ-тэй хэлцэл хийх этгээд болохыг мэдсэн өдөрт багтаан хуулийн асуудал хариуцсан ажилтан /цаашид хуульч гэх/ болон Гүйцэтгэх захирал /цаашид ГЗ гэх/-д хавстралт СХЖ-05 маягтыг холбогдох баримт бичгийн хамт и-мэйлээр мэдэгдэнэ.

3.3. Хуульч нь өөрийн үүргийн хүрээнд компанийн байгуулах хэлцэл нь энэ журмын 2.2-д заасан СЗ-тэй хэлцлийн хэв шинжийг хангаж буй бол ТУЗ/ ХЭХ-аас зөвшөөрөл авах шаардлагатай эсэхэд Хууль зүйн дүгнэлт боловсруулах алгоритмын дагуу ажлын 1 өдөрт багтаан ГЗ, НБД-д и-мэйлээр мэдэгдэнэ.

3.4. Санхүү бүртгэл хариуцсан нэгж нь СЗ-тэй хэлцлийн зүйлийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээ болон хэлцэл хийх зардлын хэмжээг Үндсэн хөрөнгө худалдан авах, ажил үйлчилгээ худалдан авах ажлын алгоритмын дагуу судалж ГЗ, НБД–д и-мэйлээр хүргүүлнэ.
3.5. НБД нь энэ журмын 3.5-д заасны дагуу ирүүлсэнээс хойш ажлын 2 хоногт багтаан доор дурдсан ажлыг гүйцэтгэнэ Үүнд:
  - 3.5.1. Хэлцэл нь ТУЗ/ХЭХ-аас зөвшөөрөл авах шаардлагатай хэлцэл бол ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ;
  - 3.5.2. Энэ журмын 3.5.1-д хэлцлийг хийх зөвшөөрөл олгох эсэх, ХЭХ-аар хэлэлцүүлэх эсэх асуудлыг ТУЗ-д хүргүүлж шийдвэрлүүлнэ.
  - 3.5.3. Хэлцэл нь ТУЗ/ХЭХ-аас зөвшөөрөл авах шаардлагагүй хэлцэл бол энэ талаар ТУЗ, Гүйцэтгэх захиралд и-мэйлээр мэдэгдэнэ.

3.6. НБД нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг хавсралт СХЖ-06 маягтын дагуу тухай бүр бүртгэнэ.
3.7. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тохиолдолд тус хэлцлийг зөвхөн бичгээр хийнэ.
3.8. НБД нь тайлант хугацаанд хийсэн СЗ-тэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны улирал бүрийн ээлжит хуралд танилцуулна.
3.9. НБД нь СЗ-тэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг АЧ мэдээллийн журамд заасны дагуу олон нийтэд мэдээллэнэ.

## 4. ДӨРӨВ.ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

4.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй.Үүнд:
  - 4.1.1. Өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдүүлэх;
  - 4.1.2. Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээдийг шийдвэр гаргах ажиллагаанд оролцохоос татгалзах;
  - 4.1.3. Хуульд зааснаас бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй этгээдийн хувийн нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх;
  - 4.1.4. Энэ журамд заасан бусад;

4.2. НБД нь дараах үүргийг хүлээнэ.Үүнд:
  - 4.2.1. Энэ журмын 2.1-д заасан хувьцаа эзэмшигч мэдүүлгийг хугацаандаа гаргаж өгөхийг шаардах;
  - 4.2.2. ТУЗ/ХЭХ-ын саналын эрхийг тодорхойлон ТУЗ эсхүл ХЭХ-ын даргад мэдэгдэх;
  - 4.2.3. Хуульд зааснаас бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй этгээдийн хувийн нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх;
  - 4.2.4. Шаардлагатай тохиолдолд сонирхлын зөрчлийн мэдүүлэг болон СЗ-тэй хэлцлийн мэдээллийг нотлох баримт бичгийг шаардах;
  - 4.2.5. ЭБАТ, хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн мэдээлэл нь бүрэн бус, алдаатай тохиолдолд залруулахыг шаардах;
  - 4.2.6. СЗ-тэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон эсэх мэдээллээр энэ журмын 2.2-д заасан этгээдийг хангах;
  - 4.2.7. СЗ-тэй хэлцэл хийх этгээдүүдийн жагсаалтыг нийт ажилтнуудад нээлттэйгээр компанийн мэдээллийн санд байршуулах;
  - 4.2.8. Энэ журамд заасан бусад;

4.3. Компанийн хуульч дараах үүрэгтэй.Үүнд:
  - 4.3.1. Аливаа гэрээ, хэлцлийг хянахдаа компанийн тухай хууль, энэхүү журамд тодорхойлсон сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байгаа эсэхийг хянах;
  - 4.3.2. Шаардлагатай тохиолдолд сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх, цаашид үүсч болох эрх зүйн үр дагаврын талаар ГЗ-д зөвлөмж бэлтгэж танилцуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах;
  - 4.3.3. Сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах талаар зөвлөмж өгөх;
  - 4.3.4. Энэ журамд заасан бусад;

## 5. ТАВ.ХАРИУЦЛАГА

*"Нэйшнл Лайф Даатгал" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 11 сарын 18-ны өдрийн 02/23-41 тоот тогтоолын хавсралт*

5.1. Энэхүү журамд заасан үүргийг зөрчсөн ажилтанд компанийн Хөдөлмөрийн харилцааны журамд заасны дагуу хариуцлага оногдуулна.

5.2. Компанийн эрх бүхий албан тушаалтанд Хөдөлмөрийн харилцааны журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулсан нь компанид учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.3. СЗ-тэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

5.4. Энэ журмын 2.1-д заасан СЗ-тэй хэлцэл хийх этгээд нь энэ журмын 2.8, 3.1-д заасан мэдээллийг өгөх үүргээ хугацаанд биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол уг хохирлын хэмжээгээр эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

## 6. ЗУРГАА.БУСАД ЖУРАМТАЙ УЯЛДАХ

6.1. Энэхүү журмын хүрээнд үйлдэгдэх баримт бичгийг "Баримт бичиг хөтлөх журам"-д заасны дагуу хөтөлнө.

6.2. Энэхүү журамд заасан өгөгдлийн санг үүсгэх, хэрэглэх, хянах, тордоход "Өгөгдлийн сангийн журам"-ыг баримтална.

6.3. Энэхүү журамд заасан ажлыг гүйцэтгэх явцад зөрчил, доголдол илэрвэл компанийн "Оношилгооны журам"-ын дагуу оношилгоо хийнэ.

6.4. Энэхүү журмын хэрэгжилтэд "Мониторинг зохицуулалтын журам"-д заасны дагуу мониторинг хийнэ.

6.5. Энэхүү журамд заасан ажлын хүрээнд олон нийтэд хүргүүлэх мэдээлэл болон АЧ мэдээллийг бэлтгэх, хүргүүлэх, хүлээн авах, танилцуулахад "Нэйшнл лайф даатгал ХХК-ийн АЧ мэдээллийн журам"-ыг баримтална.

6.6. Энэхүү журамд заасан ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг "Санхүүгийн журам"-д заасны дагуу төлөвлөж гүйцэтгэлийг тайлагнана.

**-----оОо-----**

УЛААНБААТАР ХОТ
National Life
НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ ХХК
1118269420
5156955 СБТ10099

я

| СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ЖУРМЫН ХАВСРАЛТ | | |
|---|---|---|
| **№** | **Маягтын дугаар** | **Хавсралтуудын жагсаалт** |
| 1 | СЗХЖ-01 | Журмын зорилгын үр дүнгийн хэмжүүр үзүүлэлтүүд |
| 2 | СЗХЖ-02 | Сонирхол зөрчилтэй этгээдийг тодорхойлох маягт |
| 3 | СЗХЖ-03 | НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг |
| 4 | СЗХЖ-04 | Хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл |
| 5 | СЗХЖ-05 | Сонирхлын зөрчлийн хэлцлийн тухай мэдэгдэх хуудас |
| 6 | СЗХЖ-06 | Сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэгдсэн бүртгэл |

189

# "НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДҮҮЛЭГ

*Миний бие Нэйшнл лайф даатгал эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч болохын хувьд Компанийн тухай хуулийн 85.1 болон 99.2-д заасан үүргийн дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг компанид хүргүүлж байна.*

| 1 | НЭГ.МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ | |
|---|---|---|
| 1.1 | Ургийн овог: | |
| 1.2 | Эцэг/эхийн нэр: | |
| 1.3 | Нэр: | |
| 1.4 | Регистрийн дугаар: | |
| 1.5 | Иргэний үнэмлэхийн дугаар: | |
| 1.6 | Оршин суугаа газрын хаяг: | |
| 1.7 | Гар утас: | |
| 1.8 | Ажлын утас: | |
| 1.9 | Цахим шуудангийн хаяг: | |
| 2 | Боловсрол, мэргэжил: | |
| 2.1 | Газар,алба: | |
| 2.2 | Албан тушаал: | |
| 2.3 | Мэдүүлэг гаргагчийн Нэйшнл лайфд эзэмшдэг хувьцааны тоо | |
| 2.4 | Мэдүүлэг гаргах үндэслэл: | |
| 2.5 | Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо: | |

## ХОЁР. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

**2 МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ**

| | Овог нэр | Тантай ямар хамааралтай болох | Регистерийн дугаар | Оршин суугаа хаяг | Ажиллаж буй байгууллага | Эрхэлж байгаа албан тушаал | Нэйшнл лайфын хувьцааг эзэмшдэг эсэх | Эзэмшдэг хувьцааны тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | | эхнэр | ... | ... | .. | | | |
| 2.2 | | | | | | | | |
| 2.3 | | | | | | | | |
| 2.4 | | | | | | | | |
| 2.5 | | | | | | | | |
| 2.6 | | | | | | | | |
| ... | | | | | | | | |
| ... | | | | | | | | |
| ... | | | | | | | | |
| ... | | | | | | | | |
| ... | | | | | | | | |
| ... | | | | | | | | |

***Тайлбар:** Мэдүүлэг гаргагч эхнэр, нөхөр, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү, эцэг, эх, мэдүүлэг гаргагчтай хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүдийн мэдээллийг оруулна*

**3 МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ХУВЬЦААГ НЬ ЭЗЭМШДЭГ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

| 3.2 | Мэдүүлэг гаргагчийн хувьцааг нь эзэмшдэг компанийн нэр, РД | Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Компанийн нийт хувьцааны тоо | Мэдүүлэг гаргагчийн эзэмшдэг хувьцааны тоо | Тухайн компанид хувьцаа эзэмшдэг нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр | Нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшдэг хувьцааны тоо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1 | | | | | | | |
| 3.2.2 | | | | | | | |
| 3.2.3 | | | | | | | |

**Тайлбар:** Нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт эхнэр, нөхөр, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү, эцэг, эх, мэдүүлэг гаргагчтай хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүдийн мэдээллийг оруулна

**3.2 МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ОРЛОГООС ШУУД БОЛОН ШУУД БУСААР ХУВЬ ХҮРТЭХ НӨХЦӨЛТЭЙ ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

| 3.2.1 | Гэрээний нэр | Гэрээнд оролцогч талуудын овог нэр/компанийн нэр | гэрээний үргэлжлэх хугацаа | Мэдүүлэг гаргагчийн орлогоос хувь хүртэх нөхцөл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| ... | | | | | |
| ... | | | | | |
| ... | | | | | |

**Тайлбар:** Зуучлалын гэрээ, хамтран ажиллах гэрээ зэрэг тухайн гэрээний хэрэгжилтийн хүрээнд бий болсон орлогоос нь тодорхой хувийг эсхүл бүхэлд нь мэдүүлэг гаргагч авахаар тохиролцсон гэрээний мэдээллийг оруулна.

194

## 3 МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНИЙ ХУВЬЦААГ НЬ ЭЗЭМШДЭГ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

| 3.2 | Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүний нэр | Хувьцааг нь эзэмшдэг компанийн нэр | Хувьцааг нь эзэмшдэг компанийн РД | Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Компанийн нийт хувьцааны тоо | Тухайн компанид хувьцаа эзэмшдэг нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр | Нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшдэг хувьцааны тоо | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1 | | | | | | | | |
| 3.2.2 | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

Тайлбар: Нэгдмэл сонирхолтой этгээд гэдэгт эхнэр, нөхөр, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү, эцэг, эх, мэдүүлэг гаргагчтай хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүдийн мэдээллийг оруулна.

### ДӨРӨВ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОРЛОГООС ШУУД БОЛОН ШУУД БУСААР ХУВЬ ХҮРТЭХ НӨХЦӨЛТЭЙ ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

| 3.2.1 | Гэрээний нэр | Гэрээнд оролцогч талуудын овог нэр/компанийн нэр | гэрээний үргэлжлэх хугацаа | Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн гишүүний орлогоос хувь хүртэх нөхцөл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Тайлбар: Зуучлалын гэрээ, хамтран ажиллах гэрээ зэрэг тухайн гэрээний хэрэгжилтийн хүрээнд бий болсон орлогоос нь тодорхой хувийг эсхүл бүхэлд нь мэдүүлэг гаргагч авахаар тохиролцсон гэрээний мэдээллийг оруулна.

**3.3** Компаниас бусад хэлбэртэй хуулийн этгээдийн гишүүнчлэл

| № | Байгууллагын нэр | гишүүнчлэл | Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |

*Тайлбар:*
*Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, үүсгэн байгуулагч, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.*

**3.4** Албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдье.

Гарын үсэг:

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: ........................................./ /

/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... оны ... дугаар сарын ...-ны өдөр

СЗЖ-04

| ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ | | | |
|---|---|---|---|
| **I** | **Компанийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээд** | | |
| № | *Хувьцаа эзэмшигчийн нэр* | *Эзэмшиж буй хувьцааны хувь* | *Хувьцаа эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр* |
| 1.1 | | | |
| 1.2 | | | |
| 1.3 | | | |
| | | | |
| | | | |
| **I** | **Компанийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээд** | | |
| **II** | ***Компанийн эрх бүхий албан тушаалтны овог нэр*** | ***Эрхэлж буй албан тушаал*** | ***Компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд*** |
| 2.1 | | | |
| 2.2 | | | |
| 2.3 | | | |
| ... | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

195

<table>
<tr><th colspan="5">Сонирхлын зөрчлийн хэлцлийн тухай мэдэгдэх хуудас</th></tr>
<tr><td>1</td><td></td><td colspan="3">Огноо:</td></tr>
<tr><td colspan="5">_____________ овогтой _________________- би /миний нэгдмэл сонирхолтой этгээд/ нь Нэйшнл лайф даатгал компанитай ......................... /гэрээний нэршлийг оруулах /-г байгуулахаар төлөвлөж байгаа байгаа бөгөөд энэхүү хэлцлийн хүрээнд сонирхлын зөрчил үүссэн болохыг Компанийн тухай хуулийн 91.1.3-д заасан үүргийн дагуу мэдэгдэж байна.</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="5"></td></tr>
<tr><td>3</td><td colspan="4">Сонирхлын зөрчил үүсгэж буй субъект: /аль тохирохын чеклэх/</td></tr>
<tr><td>№</td><td colspan="3">Сонирхлын зөрчилтэй хэлцлийн оролцогч тал</td><td>Тайлбар</td></tr>
<tr><td rowspan="2">3.1</td><td>☐</td><td rowspan="2">Компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг эзэмшигч</td><td>Дангаараа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч</td><td></td></tr>
<tr><td rowspan="3">3.2</td><td>☐</td><td rowspan="3">Компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээд</td><td>Хувьцаа эзэмшигчийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Хувьцаа эзэмшигчийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Хувьцаа эзэмшигч хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд компанитай хийх гэрээнд оролцогч талууд</td><td></td></tr>
<tr><td rowspan="7">3.3.</td><td>☐</td><td rowspan="7">Компанийн эрх бүхий албан тушаалтан</td><td>Гүйцэтгэх захирал</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Санхүү хариуцсан нэгжийн ХМ</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Даатгалын борлуулалт хариуцсан нэгжийн ХМ</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Ерөнхий нягтлан бодогч</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Компанийн дүрэмд заасан бусад ажилтан</td><td></td></tr>
<tr><td rowspan="3">3.4.</td><td>☐</td><td rowspan="3">Компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд</td><td>Эрх бүхий албан тушаалтны эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Эрх бүхий албан тушаалтны эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Эрх бүхий албан тушаалтан хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд компанитай хийх гэрээнд оролцогч талууд</td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>4</td><td></td><td colspan="3">Сонирхлын зөрчил үүсгэж буй нөхцлийн агуулга /аль тохирохыг тэмдэглэх/</td></tr>
<tr><td></td><td colspan="3">Сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй хэлцэл хийх этгээд болон хэлцлийн бусад оролцогч талын хоорондын харилцаа</td><td>Тайлбар</td></tr>
<tr><td>4.1</td><td>☐</td><td colspan="2">Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа</td><td></td></tr>
<tr><td>4.2</td><td>☐</td><td colspan="2">Хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа</td><td></td></tr>
<tr><td rowspan="3"></td><td>☐</td><td rowspan="3"></td><td>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Гүйцэтгэх захирал байх</td><td></td></tr>
<tr><td>☐</td><td>Санхүүгийн албаны дарга байх</td><td></td></tr>
</table>

146

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.3. | ☐ | *Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан байх тохиолдол* | *Ерөнхий нягтлан бодогч байх* | |
| | ☐ | | *Ерөнхий мэргэжилтэн байх* | |
| | ☐ | | *Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга байх* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан бусад ажилтан* | |
| 4.4. | ☐ | *Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг эзэмшигч байх тохиолдол* | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа эзэмшиж байгаа* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;* | |
| 4.5. | ☐ | *Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан байх тохиолдол* | *Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх* | |
| | ☐ | | *Гүйцэтгэх захирал байх* | |
| | ☐ | | *Санхүүгийн албаны дарга байх* | |
| | ☐ | | *Ерөнхий нягтлан бодогч байх* | |
| | ☐ | | *Ерөнхий мэргэжилтэн байх* | |
| | ☐ | | *Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга байх* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан бусад ажилтан* | |
| 4.6 | ☐ | *Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг эзэмшигч байх тохиолдол* | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа эзэмшиж байгаа* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;* | |
| 4.7 | ☐ | *Хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан байх тохиолдол* | *Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх* | |
| | ☐ | | *Гүйцэтгэх захирал байх* | |
| | ☐ | | *Санхүүгийн албаны дарга байх* | |
| | ☐ | | *Ерөнхий нягтлан бодогч байх* | |
| | ☐ | | *Ерөнхий мэргэжилтэн байх* | |
| | ☐ | | *Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга байх* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан бусад ажилтан* | |
| 4.8 | ☐ | *Хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг эзэмшигч байх тохиолдол* | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа эзэмшиж байгаа* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;* | |
| | ☐ | | *Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх* | |
| | ☐ | | *Гүйцэтгэх захирал байх* | |
| | ☐ | | *Санхүүгийн албаны дарга байх* | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.9 | ☐ | *Хэлцэлд төлөвлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан байх тохиолдол* | *Ерөнхий нягтлан бодогч байх* | |
| | ☐ | | *Ерөнхий мэргэжилтэн байх* | |
| | ☐ | | *Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга байх* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн дүрэмд заасан бусад ажилтан* | |
| 4.1 | ☐ | *Хэлцэлд төлөвлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг эзэмшигч байх тохиолдол* | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа эзэмшиж байгаа* | |
| | ☐ | | *Тухайн хуулийн этгээдийн энгийн хувьцааны 20-оос дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;* | |
| 4.11 | ☐ | *Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдол* | | |
| | | | | |
| 5 | | **Сонирхлын зөрчил нөхцөл үүсгэж буй тохиолдлын агуулга:** */мэдэгдэж буй нөхцлийн товч агуулгыг бичих/* | | |
| | | | | |
| | | Гарын үсэг: | | |
| | | Бүртгэсэн: _______________ | | |

197

| СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | Сонирхлын зөрчилтэй этгээдийн нэр | Сонирхлын зөрчил үүсгэсэн харилцаа | Сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэр | Сонирхлын зөрчилтэй хэлцлийн гол агуулга | Хэлцлийн үргэлжлэх хугацаа | Хэлцлийн үнийн дүн | ТУЗ/ХЭХ-ээс зөвшөөрөл олгосон эсэх | ТУЗ/ХЭХ-ын шийдвэрийн холбоос |
| 1 | | | | | | | ☐ | |
| 2 | | | | | | | ☐ | |
| 3 | | | | | | | ☐ | |
| 7 | | | | | | | ☐ | |
| 4 | | | | | | | ☐ | |
| 5 | | | | | | | ☐ | |
| 6 | | | | | | | ☐ | |
| 8 | | | | | | | ☐ | |
| 9 | | | | | | | ☐ | |
| 10 | | | | | | | ☐ | |
| 11 | | | | | | | ☐ | |
| 12 | | | | | | | ☐ | |
| 13 | | | | | | | ☐ | |
| 14 | | | | | | | ☐ | |
| 15 | | | | | | | ☐ | |
| | | | | | | | ☐ | |